


Нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоох, ажлын туршлага судалж өөрийн ажилдаа нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор ГАДААД, ДОТООД АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ зорилт тавьж ажиллаж байна.

БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хотын Ардын Төлөөлөгчдийн хурлын хооронд эдийн засаг, эрүүл мэнд, соёл, боловсрол, спортын болон бусад салбарт харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр санамж бичиг байгуулав. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Энхтайваны сангийн хандиваар Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд баригдсан Хүүхдийн нэгдсэн эмнэлэгт Эрээн хотын Ардын Төлөөлөгчдийн Хурлаас 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг бэлэг болгон гардуулан өгөв.



ИТХ-ын Төлөөлөгчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур, Хайлаар, Амгаланбаатар хот, БНТУ-ын Анкара хотын Синжан дүүрэг, Анталия хотын Кемир дүүрэг, БНСУ-ын Сөүл хотын Сонгбук дүүрэгт тус тус ажлын айлчлал хийж, туршлага судалсан.



Холбогдох хаяг:

ЧД-ийн ИТХ

Утас 313193, 96070008 Н.Янжинлхам/Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан/

Web site: www.chingelteicouncil.mn

АЙЛЧЛАЛЫН ҮР ДҮНД: БНХАУ-ын Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 14 дэх удаагийн үзэсгэлэнд Чингэлтэй дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах, Манжуур хотод “Чингэлтэйд үйлдвэрлэв төв”-ийг нээх талаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт яриа хэлэлцээрийг хийснээс гадна, БНСУ-ын Сөүл хотын Сунгпа дүүрэгт 9 дүгээр сард зохион байгуулагдах Олон Улсын хүүхдийн урлагийн наадамд дүүргийн Ардын урлагийн хүүхдийн хамтлагийг оролцуулах, БНТУ-ын Синжан хотын үйлдвэрлэлийн бүсийн сургалт үйлдвэрлэлийн төвд 4 төрлийн мэргэжлээр ажилтан бэлтгэхэд жил бүр 5-10 иргэнийг ТИКА олон улсын байгууллагаар дамжуулан сургах, Анталия хотын Кемир дүүрэгтэй аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, санамж бичигт үзэглэх зэрэг яриа хэлэлцээрийг хийлээ.



Холбогдох хаяг:

ЧД-ийн ИТХ

Утас 313193, 96070008 Н.Янжинлхам/Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан/

Web site: www.chingelteicouncil.mn